



МОНГОЛ УЛС
ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2017 оны 09 сарын 13 өдөр

Дугаар А/377

Мандалговь

Г Хөрөнгө гаргах тухай 7

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.1, Сангийн сайдын 2012 оны 11 дүгээр сарын 15-ны өдрийн 239 дүгээр тушаалаар батлагдсан Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журмын 2.1.3 заалт, Аймгийн Засаг даргын зөвлөлийн хурлын 2017 оны 09 дугаар сарын 13-ны өдрийн 12 дугаар тэмдэглэлийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

Нэг. Аймаг орон нутгийн хэмжээнд үйл ажиллагаа явуулж үйлдвэрлэл үйлчилгээ эрхлэгч иргэн, малчин өрх, жижиг дунд үйлдвэрлэл эрхлэгчдийн бүтээгдэхүүнийг олон нийтэд сурталчлах, экспортийг дэмжих инноваци болон өртөг шингэсэн шилдэг бүтээгдэхүүнийг шалгаруулж урамшуулах, худалдан борлуулах орчин бүрдүүлэх зорилго бүхий "Дундговь түншлэл-2017" үзэсгэлэн худалдааны шагналын зардлыг хавсралтаар баталсугай.

Хоёр. Зардалд шаардагдах 1.950.000 /Нэг сая есөн зуун тавин мянган/ төгрөгийг аймгийн Засаг даргын нөөц сангаас гаргахыг ЗДТГ-ын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч /Ц.Эрдэнэсүрэн/, нягтлан бодогч /Ц.Даваа/-д зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА  БАТ-ЭРДЭНЭ



0200877